



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

2020.01.10

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид яам гэх/-ны 2019 оны үйл хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга

Яамны 2019 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, СЗХ-наас гарсан шийдвэрийн хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ гэсэн 12 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **86.0%**-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Яамны 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Яамны 2019 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 192 арга хэмжээний 135 нь хэрэгжсэн, 37 нь 70%-ийн хэрэгжилттэй, 14 нь 30%-ийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 5 арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон тул үнэлээгүй, хэрэгжилт 88,3%-тай байна.

Яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрэгжүүлэх нэгж, хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

№	Нэгжийн нэр	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хассан	Биелэлт хувь
			100%	70%	30%	0%		
1	БТГ	38	28	8	1	-	1	91.6%
2	ТЗУГ	44	33	11	-	-	-	92.5%
3	ХШҮДАГ	27	22	3	-	1	-	92.7%
4	АЗБХЗГ	47	35	8	2	-	2	91.6%
5	АТБХЗГ	27	16	7	4	-	-	81.9%
6	ТЗДТБХЗГ	35	22	9	4	-	-	84.3%
7	АТБХЗХ	29	18	5	4	-	2	84.1%



	НИЙТ	192	135	37	14	1	5	88.3%
--	------	-----	-----	----	----	---	---	-------

Хэрэгжилт хангалтгүй буюу 0, 30%-тай байгаа 14 арга хэмжээ:

1/ 1.1.5 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулах /АТБХЗХ. 1-2 улирал. Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна/

Биелэлт: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан зорчигч, тээврийн агаарын хөлөг, түүний сэлбэг, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлж буй зохицуулалтын хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээний тайлан, түүний дагуу иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, үр нөлөөний судалгаа, эдийн засгийн тооцоо судалгааг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Сангийн сайдад хүргүүлэх шатанд байна.

2/ 1.1.15 Хөшигийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах урьдчилсан судалгаа хийх /БТГ. 4 улирал. Урьдчилсан судалгаа хийгдсэн байна/

Биелэлт: Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд Богдхан төмөр замын ТЭЗҮ боловсруулах тендер зарлагдсан. Богдхан төмөр замын ТЭЗҮ-д логистикийн төвийн тооцоо судалгаа хамаарагдах тул Хөшигийн хөндийд байгуулагдах тээвэр логистикийн төвийн урьдчилсан судалгаа уг ТЭЗҮ-ийн хүрээнд хийгдэнэ.

3/ 1.1.17 Цахилгаан тээврийн хэрэгсэл болон сэлбэг эд ангийг гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл боловсруулах /АТБХЗГ. 1-2 улирал. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна/

Биелэлт: 2018 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 970.846 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс цахилгаан хөдөлгүүртэй 173, хосолсон хөдөлгүүртэй 161.426, хийн хөдөлгүүртэй 20.398 тээврийн хэрэгсэл тус тус эзэлж байна. Цахилгаан тээврийн хэрэгслийг Гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх талаар холбогдох хуулийн болон Засгийн газрын хуралдааны төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авахаар ажиллаж байна.

4/ 3.3.2 АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн Багц-4: Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн болон зөвлөхийн гэрээний хэрэгжилтийг хангуулах /АЗБХЗГ. 1-4 улирал. Зам, гүүрийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг 100 хувь хангасан байна/

Биелэлт: Зам барилгын ажлын гүйцэтгэгчийн тендерт Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 834 дугаар бүхий шийдвэр гарсан. Тус шийдвэрээр тус багцад 2018.05.11-ний өдөр "Алтайн зам" ХК-тай барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан боловч АХБ-аас тус банкны Худалдан авах ажиллагааны журамд нийцэхгүй үндэслэлээр санхүүжүүлэхгүй боломжгүй гэж мэдэгдсэн. АХБ-аас тус зам барилгын ажлын гүйцэтгэгчийн тендерт гарсан шүүхийн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд АХБ-ны хөрөнгө оруулалтыг ашиглах боломжтой талаар мэдэгдлийг 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн. Шүүхийн шийдвэр хэрэгжсэн талаарх тодорхойлолт хүссэн албан бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр 01/1028 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2019 оны 03 сарын 21-ний өдрийн 1/7099 албан тоотгоор хариу ирүүлсэн бөгөөд шүүхийн шийдвэр хэрэгжсэн талаарх тодорхойлолтыг ирүүлсэн. АХБ-нд шүүхийн шийдвэр хэрэгжсэн тул тус банкны хөрөнгөөр зам барилгын

ажлыг хэрэгжүүлэх, мөн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг АХБ-аас ирүүлсэн. Тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж байна.

5/ 3.3.16 Өгийнуур – Батцэнгэл - Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих /Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай/ /АЗБХЗГ. 1-4 улирал. 63 км авто замын барилгын ажлыг тусгагдсан хөрөнгийн хүрээнд хэрэгжүүлэх/

Биелэлт: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тухайн төслийн эхний 63 км замыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр XIII.1.1.48 дугаартайгаар тусгагдсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. Тендерийг зарлаж, 2019.06.14-ний өдөр нээсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй. Дахин тендер шалгаруулалтыг зохион байгуулж 2019 оны 11 дүгээр сарын 10-нд "Хурдны зам" ХХК-тай гэрээ байгуулсан.

6/ 4.1.3 Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх /АТБХЗГ. 3 улирал. 4 хилийн боомт дээр эхлүүлсэн байна/

Биелэлт: 2019 онд "АТҮТ" ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны дагуу 8000 шошго худалдан авах тендер зарласан. Энэхүү тендерт 9 компани оролцсоноос 2019 оны 4 сарын 29-ний өдөр шалгаруулахад "Бодь электроникс" ХХК шалгарсан.

Мөн тус яамны авто зогсоолын орох, гарах хаалга дээр 2019 оны 4 сарын 8-наас RFID шошго уншигч төхөөрөмж байрлуулсан туршилтын ажлыг эхлүүлэн 9 дүгээр сарын 15-ны өдрөөс яамны ажилтнуудын автомашинд шошго нааж бүртгэх ажлыг эхлүүлсэн.

Хилийн боомт дээр RFID системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд ЗТХЯ, ГЕГ болон АТҮТ ТӨҮГ хамтарсан Ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газар, "АТҮТ" ТӨҮГ-ын 2019 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн А/103, а/171 хамтарсан тушаалаар байгуулсан.

Ажлын хэсэгт тус яамнаас 3, Гаалийн ерөнхий газраас 5, "АТҮТ" ТӨҮГ-аас 7 төлөөлөл орж ажиллаж байна.

Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж байна.

7/ 4.3.1 Тусгай замын автобус /BRT/-г нэвтрүүлэх I шатны ажлыг хэрэгжүүлэх /АТБХЗГ. 2 улирал. Тусгай замын автобус /BRT/-г нэвтрүүлэх I шатны барилгын ажлыг эхлүүлсэн байна/

Биелэлт: 2018, 2019 онуудад төслийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 16 тендерийн материалын төслийг Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн боловч тендер зарлахтай холбоотой хариу ирүүлээгүй.

Мөн дээр дурдсанчлан Азийн хөгжлийн банкны зохих зөвшөөрөл хугацаа удсан зэрэг бодит шалтгаан байсан хэдий ч Сангийн сайдын 2019.11.13-ны өдрийн 01/5339 тоот албан бичгээр тус төслийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргаад байгаа бөгөөд НЗДТГ энэхүү байр суурийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, төслийг үргэлжлүүлэх байр сууриа илэрхийлээд байна.

Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга нарын 2019.12.13-ны өдрийн албан уулзалтын үеэр Нийслэлийн Засаг дарга тусгай замын автобусны нэвтрүүлэх төслийг цааш дахин үргэлжлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад тавьсан бөгөөд уг төслийг эрчимжүүлэх талаар судлахаа Сангийн сайд илэрхийлсэн.

8/ 5.2.1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх /ТЗДТБХЗГ. 2-4 улирал. барилгын ажлын 80% гүйцэтгэсэн байна/

Биелэлт: Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх санхүүжилт болон "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувь эзэмшлийг Засгийн газрын 304 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд барилгын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын Ерөнхий төлөвлөгөө гарган биелэлт 90%-тай байна. "Тавантолгой төмөр зам" ХХК нь захиалагч бөгөөд Ерөнхий гүйцэтгэгчээр "Бодь интернэшнл" ХХК-тай гэрээ байгуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж Тавантолгой-

Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бичиг баримт, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Монголын төмөр зам” ТӨХК-аас “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлсэн. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг тогтоон баталж ТУЗ-ийг шинэчлэх зэрэг ажлууд хийгдсэн. Цаашид төслийн барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлаар хуулийн хүрээнд шат дараатай гүйцэтгэж, барилгын ажлыг 2020 онд эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

9/ 5.2.3. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх /ТЗДТБХЗГ. 4 улирал. барилгын ажил эхэлсэн байна/

Биелэлт: Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан бөгөөд царигийн өргөөний хэмжээг УИХ-аар тогтоосны дараа барилгын ажлыг эхлүүлнэ. Цариг шийдвэрлэгдээгүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдээд байна. УИХ-ын 2019 оны Хаврын чуулганаар хэлэлцүүлэх явцад тус төслийн ТЭЗҮ, тооцоо судалгааг дахин нягтлах гэсэн шалтгаанаар Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл гарч буцаан татсан. “Нарийнсухайт төмөр зам” ХХК-иас барилгын ажил эхлүүлэх чиглэл хүссэн албан бичиг ирүүлсний дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон “Монголын төмөр зам” ХХК-д 2018 оны 232 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар чиглэл хүргүүлсэн.

10/ 5.2.10. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх /ТЗДТБХЗГ. 9 сар. Барилгын ажлыг эхлүүлсэн байна/

Биелэлт: “Зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах тухай” тогтоолоор Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангилалаар тусгай хамгаалалтанд авсанаар батлагдсан чигээс 100 гаран км дайран өнгөрсөн, мөн Ханжаргалантын байгалийн нөөц газартай давхцсанаар тухайн чиглэлийн төмөр замын ажил удаашраад байна. Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын төслийг Хужирын голын хөндийгөөр зэрэгцүүлэн явуулах боломжийг судалж, батлагдсан чигийн дагуу 47 км газарт Эгийн голын усан цахилгаан станц төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр замын трасстай огтлолцох 6 цэгийг газар дээр нь үзэж Хужирын голын хөндийгөөр уялдуулан явуулах боломжтой гэж үзэн Ажлын хэсгийн 2019.07.16-ны 19/228/07 дугаартай дүгнэлтийг гаргасан. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын Концессын гэрээний хугацаа 2020 оны 4 сард дуусахтай холбогдуулан Үндэсний хөгжлийн газраас 2019.08.26-ны өдрийн 01/2255 дугаартай албан бичгээр ажлын хэсэг байгуулах санал ирүүлсэн. Уг саналын дагуу концесс эзэмшигч “Нортерн рэйлвэйс” ХХК-ны захирал н.Ган-Очиртой уулзалт зохион байгуулж хөвсгөл аймгийн Мөрөн чиглэлээр трассыг өөрчлөх боломжийг судлах, өмнөх шийдвэр, мэдээллийг яамны удирдлагуудад танилцуулах чиглэл өгсөн.

11/ 5.4.2. “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах /ТЗДТБХЗГ 1-4 улирал Журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

Биелэлт: Журмын төсөл боловсруулагдсан бөгөөд Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

12/ 6.2.4. “Чингис хаан” ОУНБ-ыг шинэ нисэх буудлыг нүүлгэн шилжүүлж, Буянт-Ухаа дахь нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах /АТБХЗХ. 2-3 улирал. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна/

Биелэлт: Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа ашиглалтад оруулахаар хэлэлцээ хийгдсэн. “Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-г Зам тээврийн хөгжлийн сайд 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталсан. 4 бүлэг 135 ажил бүхий “Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-г 10 сарын хугацаанд хэрэгжүүлэн, нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ. “Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-г

Зам тээврийн хөгжлийн сайд 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталсан. 4 бүлэг 135 ажил бүхий "Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө"-г хэрэгжүүлж байна. Хамтарсан компани 73 ажлыг хариуцахаас хэрэгжүүлж эхэлсэн 64, хугацаа болоогүй 7, монгол талын төрийн байгууллагууд 62 ажлыг хариуцан хэрэгжүүлэхээс 43 ажлын хэрэгжилтийг эхлүүлсэн, 19 ажлыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна. 2019 оны 12 дугаар сарын 19-ны байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 45%-тай байна.

13/ 6.2.8. Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох бэлтгэл ажлыг хангах /АТБХЗХ. 10-12 сар. ТЭЗҮ, Зураг төслийг батлуулсан байна/

Биелэлт: ЗТХС, Сангийн сайдын 2018.12.31-ний өдрийн 305/313 дугаар хамтарсан тушаалаар Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох ажилд ИНЕГ-ын 2019 оны өөрийн орлогоос 1 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр баталсан. Иргэний нисэхийн ерөнхий газар болон "Некстстеп инженеринг" ХХК хооронд "Зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх болон бусад инженерингийн барилга байгууламжуудын ажлын зураг төсөл, төсвийг /Дорнод/ хийж гүйцэтгэх ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-07/19 дугаар гэрээг 2019 оны 10 дугаар сарын 25-ы өдөр байгуулаад байна. Гэрээт ажлын явц 2019.12.16-ны өдрийн байдлаар 30%-тай байна. Гэрээгээр гүйцэтгэгч тал 2019.12.31-ний өдрийн дотор зураг төслийг хүлээлгэж өгөх үүрэгтэй

14/ 6.2.10. Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 3С хүчин чадалтай болгох төслийг удирдлага, зохион байгуулалтаар хангах /АТБХЗХ 4-12 сар Барилгын ажлын гүйцэтгэл 20%/

Биелэлт: Тендерийг 2019.09.18-ны өдөр нээсэн боловч 1-р багц буюу барилгын ажлын тендерт 1 ч оролцогч оролцоогүй тул үнэлгээний хороо шалтгаан нөхцөлийг судалж тендерийг дахин зарлахаар ажиллаж байна. Харин 2-р багц буюу аэродромын ажлын тендерт оролцогчоос ШӨХТГ-т гомдол ирүүлсэн байсан тул тендерийг түр зогсоож, 12.04-ний өдөр дахин зарласан. Тендерийг 2019.12.16-ны өдөр нээж.

15/ 7.3.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд ажил, үйлчилгээ эрхэлдэг агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх /ХШҮДАГ 1-4 улирал. Эрсдэлийн түвшин өндөр үнэлэгдсэн 4 байгууллагад дотоод аудит хийж, тайланг Дотоод аудитын хороонд танилцуулсан байна/

Биелэлт: Хэрэгжээгүй. 0%

2.2. МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломж-гүй	Хувь
1	АЗБХЗГ	68	24	7	4	-	38	87.1%
2	АТБХЗГ	13	6	4	2	-	1	80,0%
3	ТЗДТБХЗГ	21	11	2	1	-	7	91.7%
4	АТБХЗХ	26	13	5	1	-	7	88.9%
5	БТГ	13	9	3	1	-	3	92.5%
6	"МТЗ" ТӨХК	5	-	1	-	-	4	70,0%
7	"УБТЗ" ХНН	3	3	-	-	-	-	100,0%
8	"Нортерн рейлвейс" ХХК	1	-	-	-	-	1	-
9	Далайн захиргаа	4	3	-	-	-	1	100,0%
Нийт		126	51	17	8	-	50	87.0%

ЗГҮАХ-т аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан заалтуудын 14 арга хэмжээ тэргүүлэх зорилтуудад ЗТХСайдын хэрэгжүүлэх арга хэмжээтэй давхцсан байна.

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 8, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 17 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 19.8%-ийг эзэлж байна. Үнэлэх боломжгүй 50 арга хэмжээ нийт арга хэмжээний 39.7%-ийг эзэлж байна.

Дараах шалтгааны улмаас 50 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үнэллээ. Үүнд:

Авто замын чиглэлээр:

Авто замын барилга, засварын 27 арга хэмжээг улсын төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2019 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй, 8 арга хэмжээг гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн замтай холбох 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ шүүхийн маргаантай, Тавантолгой, Сайншанд чиглэлийн бетонон хучилттай, хүнд даацын 500 км авто зам барих ТЭЗҮ-ийг боловсруулж, хөрөнгө оруулалтын нөхцөлийн тохиролцоо, судалгаа хийх арга хэмжээг Төмөр замтай зэрэгцүүлэн хүнд даацын цементбетон хучилттай 500 км авто зам барих нь эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн тул;

Төмөр замын чиглэлээр:

“Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээний ТЭЗҮ үр ашиг багатай гарсан;

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаас Оюутолгой чиглэлийн салбар төмөр замыг барих арга хэмжээ Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төслийн барилгын ажил эхэлснээр Оюутолгойн гэрээний дагуу Засгийн газрын шийдвэр гарч тус салбар төмөр зам баригдана;

“Шивээхүрэн-Сэхэ” боомтын төмөр замыг барих арга хэмжээ царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоогүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй болсон. Мөн тус чиглэлийн төмөр зам барих нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн шүүх байгууллагад шалгагдаж байгаа болно.;

“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх арга хэмжээг Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод тусгаагүй, царигийн хэмжээг тогтоогоогүй, төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигчийг шийдвэрлээгүй;

“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барих ажлыг эхлүүлэх арга хэмжээ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас УИХ-аар “Зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах тухай” тогтоолоор Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангилалаар тусгай хамгаалалтанд авсанаар батлагдсан чигээс 100 гаран км дайран өнгөрсөн, мөн Ханжаргалантын байгалийн нөөц газартай давхцсанаар төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлэх боломжгүй болсон;

Концессын гэрээгээр улсын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн ач холбогдлоор нь эрэмблэсний дагуу тус арга хэмжээг Үндэсний хөгжлийн газраас төлөвлөгөөнд тусгаад байна.

Хөвсгөл нуурт усан замын төв зогсоолыг концессын гэрээгээр барих арга хэмжээг Концесс эзэмшигч гарч ирээгүй тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлээр 2019 оны Төсвийн тухай хуульд зураг төсөл, ТЭЗҮ-г боловсруулах санхүүжилт болох 800 сая төгрөгийг улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч хөрөнгө тусгагдаагүй тул;

Агаарын тээврийн чиглэлээр:

Агаарын тээврийн салбарт Ховд, Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий аймгуудын нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх 4 арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй;

Чингис Хаан ОУНБ-ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах арга хэмжээ нь Шинэ нисэх буудлын үйл

ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа ашиглалтад оруулахаар хэлэлцээ хийгдсэн;

Тээвэр логистикийн чиглэлээр:

Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах арга хэмжээ Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд Богдхан төмөр замын ТЭЗҮ боловсруулах тендер зарлагдсан. Богдхан төмөр замын ТЭЗҮ-д логистикийн төвийн тооцоо судалгаа хамаарагдах тул Хөшигийн хөндийд байгуулагдах тээвэр логистикийн төвийн урьдчилсан судалгаа уг ТЭЗҮ-ийн хүрээнд хийгдэх тул тус тус үнэлээгүй болно.

Хэрэгжилт хангалтгүй буюу 40%-тай байгаа 8 арга хэмжээ:

- 2.107.2. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто замыг барих,
- 2.107.3. Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих
- 2.107.6. Дашинчилэн-Их тамир чиглэлийн 130 км авто замын Орхон голын 220 урт метр төмөр бетон гүүрийг барих
- 2.111.3. Богдхан төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх
- 2.114.13. Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах ЗС хүчин чадалтай болгох
- 2.118.5. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх
- 2.118.6. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- 6.16.1.3. Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Мандал сумын төв хүртэл 32 км хатуу хучилттай авто зам барих /аймаг, орон нутагт эрх шилжүүлсэн/

2.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт дараах байдалтай байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
1	АЗБХЗГ	21	17	3	-	-	1	95.5%
2	АТБХЗГ	2	-	-	1	-	2	40,0%
3	ТЗДТБХЗГ	5	3	-	-	-	2	100,0%
4	АТБХЗХ	2	-	-	-	-	2	-
5	БТГ	1	-	-	1	-	1	40,0%
6	ИНЕГ	2	-	-	-	-	2	-
7	"МТЗ" ТӨХК	1	-	-	-	-	1	-
8	"УБТЗ" ХНН	2	2	-	-	-	-	100,0%
9	"Нортерн рейлвейс" ХХК	1	-	-	-	-	1	-
10	Төслийн нэгж	1	1	-	-	-	-	100,0%
11	НЗДТГ	6	3	1	1	-	-	82,0%
Нийт		31	20	3	2	-	6	91.6%

Хэрэгжилт хангалтгүй буюу 40%-тай байгаа 2 арга хэмжээ:

- 7.3.5. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /Хэрэгжилтийн явц 30%/ 40%
- 8.3.1. Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх /Боловсруулах ерөнхий төлөвлөгөөний тоо 1/ 40%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Биелэлт хувиар
			100	70	30	0	Хугацаа болоогүй		
1	БТГ	59	36	13	2	-	8	-	89.6%
2	ТЗУГ	56	44	10	-	-	2	-	94.4%
3	ХШУДАГ	12	6	5	-	-	1	-	86.4%
4	АЗБХЗГ	78	45	21	1	-	11	-	89.6%
5	АТБХЗГ	53	26	19	4	-	4	-	82.7%
6	ТЗДТБХЗГ	79	30	29	5	-	12	3	80.9%
7	АТБХЗХ	45	26	11	2	-	6	-	87.9%
8	ИНЕГ	55	40	9	4	-	2	-	89.6%
9	ЗТХТ	19	19	-	-	-	-	-	100.0%
10	АТҮТ	23	22	1	-	-	-	-	98.7%
11	ГТХЗНТ	29	25	-	-	-	4	-	100.0%
12	МИАТ	19	17	1	-	-	1	-	98.3%
13	УБТЗ	18	16	-	-	-	2	-	100.0%
14	МТЗ	25	20	-	1	-	4	-	96.7%
15	Далайн захиргаа	31	27	-	-	-	4	-	100.0%
16	ХХНОБ	16	12	-	-	-	4	-	100.0%
17	НТОЗШША	16	15	-	-	-	1	-	100.0%
	Нийт	326	187	83	12	0	37	7	88.2%

Хууль тогтоомж, тушаал шийдвэрийн биелэлтийн 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн 11 шийдвэрээс төмөр зам, далайн тээврийн салбарын чиглэлээр 5, авто тээврийн салбар 5, агаарын тээврийн салбарын 1 асуудал байна.

Нийт 3 хуулийн 20 заалт хяналтад байгаа бөгөөд хэрэгжилт 92.5 хувьтай байна. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Усан замын тээврийн шинэчилсэн найруулга 2017 оны 05 дугаар сард батлагдсантай холбогдуулан эдгээр хуулиудаар эрх зүйн акт /дүрэм, журам, заавар, аргачлал/, бодлого, хөтөлбөр батлахаар эрх олгогдсон 20 заалтыг хяналтад авсан. Үүнээс: Усан замын тээврийн салбарын 2 журам боловсруулах ажил удаашралтай байна.

Зам, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой дараах асуудлуудын хэрэгжилт удаашралтай байна. Тухайлбал, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд 2017 онд батлуулахаар заасан Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуулийн төсөл батлагдагдаагүй байна.

Бүрэн хэрэгжээгүй байгаа 95 үүрэг даалгавраас 14 нь санхүүжилтийн асуудал шийдэгдэхгүй байгаагаас удааширсан байна.

2.5. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Биелэлт хувиар
			100	70	30	0	Хугацаа болоогүй		
1	Дэд сайд	25	20	-	1	-	1	3	96.7%
2	ТНБД	59	41	12	2	1	2	1	89.3%
3	БТГ	57	37	8	3	-	4	5	90.6%
4	ТЗУГ	37	28	4	-	-	-	5	96.2%
5	ХШУДАГ	91	55	16	1	1	10	8	91.1%
6	АЗБХЗГ	74	43	13	9	1	5	3	83.0%
7	АТБХЗГ	44	31	4	3	-	4	2	91.3%
8	ТЗДТБХЗГ	69	47	10	-	-	6	6	94.7%
9	АТБХЗХ	37	31	4	-	-	-	2	96.6%
10	ИНЕГ	98	52	11	4	2	25	4	88.2%

11	ЗТХТ	65	41	4	7	2	8	3	85.0%
12	АТҮТ	80	39	15	10	5	5	6	76.1%
13	ГТХЗНТ	49	31	6	2	1	3	6	89.5%
14	МИАТ	35	24	24	2	-	-	-	88.3%
15	УБТЗ	81	53	53	4	-	6	5	90.4%
16	МТЗ	69	42	42	5	-	3	7	88,0%
17	Далайн захиргаа	52	40	40	3	1	1	2	90.6%
18	НТОЗШША	18	17	17	-	-	1	-	100.0%
19	Төслийн нэгжүүд	8	6	2	-	1	-	-	92.5%
Нийт		604	329	101	54	14	70	36	83.5%

2019 оны I-III улиралд өгсөн зөвлөмжийн дагуу байнгын ажиллагаатай тушаал шийдвэр боловсруулахдаа ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байгаа ба хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл, Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх үндэсний зөвлөл, Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийг зохицуулах хороонууд 2019 онд хуралдсан, төлөвлөгөөгөө баталж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.

Хяналтад байгаа 604 заалтын 267 нь үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хугацаа заасан ба 337 заалт буюу 55.7% нь хэрэгжүүлэх хугацаа заагаагүй үүрэг даалгавар байна.

Авто замын чиглэл тогтоох тухай 12, агаарын тээвэрлэгчийг томилох тухай 4, тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай 8 тушаал хяналтад байгаа бөгөөд авто замын чиглэл тогтоох хүсэлт тавьсан уурхай эзэмшигч компаниуд авто зам барих хөрөнгөгүй гэсэн шалтгаанаар авто зам барилгын ажлаа эхлэхгүй, тухайн чиглэлд тээвэр гүйцэтгэх компани нь хүсэлтээ ирүүлэхгүй, агаарын тээвэрлэгчээр томилогдсон компаниуд нислэг үйлдэхгүй байгаагаас тушаалууд хэрэгжихгүй удаашралтай байна.

2.6. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Биелэлт хувиар
			100	70	30	0	Хугацаа болоогүй		
1	БТГ	26	19	4	-	-	3	-	94.8%
2	ТЗУГ	23	19	1	-	-	3	-	98.5%
3	ХШУДАГ	63	49	6	-	-	8	-	96.7%
4	АЗБХЗГ	51	42	7	2	-	2	-	95.7%
5	АТБХЗГ	18	14	2	2	-	-	-	88.9%
6	ТЗДТБХЗГ	33	29	4	-	-	-	-	96.4%
7	АТБХЗХ	8	7	1	-	-	-	-	96.3%
8	ИНЕГ	2	2	-	-	-	-	-	100.0%
9	ЗТХТ	6	6	-	-	-	-	-	100.0%
10	АТҮТ	5	5	-	-	-	-	-	100.0%
11	МИАТ	2	2	-	-	-	-	-	100.0%
12	УБТЗ	16	16	-	-	-	-	-	100.0%
13	МТЗ	5	5	-	-	-	-	-	100.0%
14	Далайн захиргаа	2	1	-	-	-	1	-	100.0%
15	төслийн нэгж	2	2	1	-	-	-	-	85.0%
16	НТҮГ	1	-	-	1	-	-	-	30.0%
Нийт		188	153	18	3	-	14	-	95.7%

2.7. Засгийн газрын хуралдаанаар 2019 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хугацаа болоогүй	Хэлэлцэх шаардлагагүй	Биелэлт хувь
			100	70	30	0				
1	БТГ	25	12	4	2	1	-	6	81,0%	
2	ТЗДТБХЗГ	7	4	1	1	-	-	1	83.3%	
3	АТБХЗГ	7	4	1	-	1	-	1	78.3%	
4	АЗБХЗГ	2	1	-	-	-	-	1	100.0%	
5	АТБХЗХ	9	3	2	1	-	-	3	78.3%	
Нийт		25	12	4	2	1	-	6	81.0%	

Засгийн газрын хуралдаанд 2019 онд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн ч хэлэлцүүлж амжаагүй дараах 7 асуудал хугацаа хоцорсон байна. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 70%
- Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 70%
- Цахилгаан тээврийн хэрэгсэл болон сэлбэг эд ангийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх хуулийн төсөл 0%
- Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 70%
- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг хангах тухай /"Зүүнбаян-Ханги" чиглэлийн төмөр замын цариг 30%
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/ Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/ 30%
- "Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр"-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 70%

2.8. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хугацаа болоогүй	Хэлэлцэх шаардлагагүй	Биелэлт хувь
			100	70	30	0				
1	БТГ	4	4	-	-	-	-	-	100,0%	
2	ТЗУГ	2	2	-	-	-	-	-	100,0%	
3	ХШУДАГ	10	10	-	-	-	-	-	100,0%	
4	АЗБХЗГ	4	3	1	-	-	-	-	92,5%	
5	АТБХЗГ	2	1	1	-	-	-	-	85,0%	
6	ТЗДТБХЗГ	6	3	3	-	-	-	-	85,0%	
7	АТБХЗХ	3	3	-	-	-	-	-	100,0%	
Нийт		29	24	5	-	-	-	-	94.8%	

2.9. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт:

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй	Биелэлт хувиар
			100	70	30	0				
1	ТЗУГ	9	6	2	-	-	1	-	92,5%	
2	БТГ	21	10	9	-	-	1	1	82,5%	
3	ТЗДТБХЗГ	20	8	10	1	-	1	-	80,5%	

4	АЗБХЗГ	14	2	9	1	-	2	-	71,7%
5	АТБХЗГ	24	5	13	3	-	1	1	71,7%
6	ХШУДАГ	22	15	4	1	-	1	1	90,5%
7	АТБХЗХ	22	6	9	3	-	4	-	73,3%
8	ИНЕГ	29	8	11	6	-	4	-	70,0%
9	“ЗТХТ” ТӨҮГ	8	1	3	2	1	1	-	52,9%
10	“АТУТ” ТӨҮГ	6	-	3	-	2	1	-	42,0%
11	“МТЗ” ТӨХК	8	1	1	-	2	4	-	42,5%
12	“УБТЗ” ТӨХК	9	1	4	1	2	1	-	51,2%
13	МИАТ	7	2	2	-	2	1	-	56,7%
14	ГТХЗНТ	3	-	1	-	2	-	-	23,2%
15	Далайн захиргаа	7	1	4	1	2	1	-	51,3%
16	“Нортерн рейлвейс” ХХК	3	1	-	-	-	-	2	100,0%
17	НЗДТГазар	1	-	1	-	-	-	-	70,0%
18	Хөлөг онгоц бүртгэл компани	3	2	1	-	-	-	-	90,0%
Нийт		100	44	45	8	-	1	2	80,3%

2.10. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Биелэлт хувиар
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	ТЗУГ	10	9	1	-	-	-	97,0%
2	БТГ	5	5	-	-	-	-	100,0%
3	АЗБХЗГ	7	6	1	-	-	-	95,7%
4	ТЗДТБХЗГ	6	5	1	-	-	-	95,0%
5	АТБХЗГ	7	7	-	-	-	-	100,0%
6	ХШУДАГ	3	3	-	-	-	-	100,0%
7	АТБХЗХ	6	5	1	-	-	-	95,0%
Нийт		14	12	2	-	-	-	95,7%

2.11. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн биелэлт дараах байдалтай байна.

№	Хэрэгжүүлэгч	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Биелэлт хувиар
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	АЗБХЗГ	14	3	4	2	5	-	45,7%
2	АТБХЗГ	24	7	8	8	1	-	62,5%
3	ТЗДТБХЗГ	11	1	4	4	2	-	45,5%
4	БТГ	10	5	1	1	3	2	60,0%
5	ХШУДАГ	1	-	-	-	-	1	100,0%
6	“АТУТ” ТӨҮГ	2	-	1	1	-	-	50,0%
7	“УБТЗ” ХНН	3	-	3	-	-	-	70,0%
Нийт		42	11	15	10	6	-	58,3%

Зам, тээврийн хөгжлийн сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллах санамж бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хөрөнгийн эх үүсвэргүйн улмаас 6 арга хэмжээ тасарсан байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын урдаас хойш чиглэлд 25.3 км Сэлбэ хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх /1.1/;
2. Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд 36 км Туул хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх /1.2/;
3. Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, Туул гол дээгүүрх төмөрбетон гүүрийн их засварын ажлыг эхлүүлэх /1.7/;
4. Нарантуул ОУХТөвийн баруун уулзвар болон төмөр зам дээгүүр гүүрэн гарцыг шинээр барих ажлыг эхлүүлэх /3.6/;
5. Сонсголонгийн уулзвар, төмөр зам дээгүүрх гүүрэн гарцын зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг эхлүүлэх /3.7/;
6. Нийтийн тээврийн болон хүнд даацын тээврийн хэрэгслийн жолоочийг мэргэшсэн жолоочийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан сургах ажлыг зохион байгуулах /5.9/.

2.12. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлангийн биелэлт дараах байдалтай байна.

ЗТХЯ-ны БТГ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 15 мэдээлэл байршуулах ба гүйцэтгэлийг авч үзвэл 84.0 хувийн хэрэгжилттэй байна.

Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
15	7	8	-	-	-	84.0%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

- 1) ЗТХЯ-ны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 192 арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа нь дараах байдлаар харьцангуй жигд төлөвлөгдсөн байна. 51 арга хэмжээ буюу 26.4% нь байнгын болон тухай бүр болон тодорхой давтамжтай хэрэгждэг ажил байна. Үлдсэн 142 арга хэмжээний 43.7%-ийг I улиралд, 33.8%-ийн II улиралд, 14.1%-ийг III улиралд, 8.4%-ийг IV улиралд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн байна.
- 2) 2019 оны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, салбарын бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээ, хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавруудыг бүрэн тусгах”, “хэрэгжүүлэх газар, хэлтсүүдийг тодорхой заах” зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.
- 3) Гэвч “хүрэх түвшинг 4 улиралд тус тусад нь төлөвлөх”, “байнга хийгддэг ажлыг жилдээ, тухай бүр, сар бүр, улирал тутам, хагас, бүтэн жилээр гэх мэтээр, бусад хугацааг “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 2.7-д “Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах тушаал, шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгавар болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээ тус бүрд хэрэгжүүлэх хугацааг тодорхой зааж өгнө. Энэхүү хугацааг сар, улирлаар тогтоох ба улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлыг үе шат бүрд хуваарилан улирал тус бүрээр төлөвлөсөн байна” гэж заасны дагуу төлөвлөх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
Жилийн турш буюу 1-4 улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 61 арга хэмжээний 19 нь байнгын хэрэгжүүлэх ажил байна. Үлдсэн 42 арга хэмжээний улирал бүрт хүрэх түвшинг тодорхойлоогүй тул өссөн дүнгээр үнэлэгдэж, хэрэгжилт бага хувьтай дүгнэгдэхэд нөлөөлсөн байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) Яамны 2019 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, СЗХ-наас гарсан шийдвэрийн хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ гэсэн 12 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 86.0%-тай байна.
- 2) Яамны 2019 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 192 арга хэмжээний 135 нь хэрэгжсэн, 37 нь 70%-ийн хэрэгжилттэй, 14 нь 30%-ийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 5 арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон тул үнэлээгүй, хэрэгжилт 88,3% буюу өмнөх улирлаас 8,8%-иар өсвөн дүнтэй байна.
- 3) 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 192 арга хэмжээний 52 арга хэмжээ буюу нийт төлөвлөсөн ажлын 27,8% нь бүрэн хэрэгжээгүй байна. Үүнээс 19 арга хэмжээ нь хууль, эрх зүйн орчинг сайжруулах, бодлогын баримт бичиг боловсруулах, судалгаа хийх ажил байна. Үүнд:
 - 1.1.2. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна. 2 улирал ТЗДТБХЗГ/ 70%
 - 1.1.3 Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах /Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна. 2 улирал АТБХЗХ/ 70%
 - 1.1.5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулах /Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. 1-2 улирал. АТБХЗХ/ 30%
 - 1.1.8 “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах /Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. 4 улирал. АТБХЗХ/ 70%
 - 1.1.12 Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах /Хөтөлбөр батлагдсан байна. 3 улирал АТБХЗГ/ 70%
 - 1.1.15 Хөшигийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах урьдчилсан судалгаа хийх /Урьдчилсан судалгаа хийгдсэн байна. 4 улирал БТГ/ 30%
 - 1.1.16 Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах /Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах. 2-3 улирал. БТГ/ 70%
 - 1.1.17.Цахилгаан тээврийн хэрэгсэл болон сэлбэг эд ангийг гааль, НӨАТ-ын албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл боловсруулах /Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. 1-2 улирал. АТБХЗГ/ 30%
 - 1.1.18 Зам, тээврийн салбарын хог хаягдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох /1 журам, 1 стандарт батлуулсан байна. АТБХЗГ/ 70%
 - 1.1.23. ОУДБ-ын “Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай” 1978 оны конвенцийн 2010 оны Манилагийн нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлэх /Конвенцийн нэмэлт, өөрчлөлтийг батлуулсан байна. 1-4 улирал. ТЗДТБХЗГ/ 70%
 - 1.3.3. Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх /Дүрэм, бүтэц зохион байгуулалтыг боловсруулж батлуулсан байна. БТГ/ 70%
 - 2.2.6. Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах /Албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан байна. 1 улирал. ТЗУГ/ 70%

- 4.1.3. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх /4 хилийн боомт дээр эхлүүлсэн байна. 3 улирал. АТБХЗГ/ 30%
 - 4.1.6. Автотээврээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийг боловсруулах /Дүрэм батлагдсан байна. 2 улирал. АТБХЗГ/ 70%
 - 5.2.2. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг аж үйлдвэрийн паркттай уялдуулан боловсруулах /ТЭЗҮ боловсруулсан байна. 1-4 улирал. ТЗДТБХЗГ/ 70%
 - 5.2.4 Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг шийдвэрлүүлэх /УИХ-д өргөн барьж хэлэлцүүлсэн байна. 6 сар ТЗДТБХЗГ/ 70%
 - 5.4.2.“Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах /Журмыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. 1-4 улирал. ТЗДТБХЗГ/ 30%
 - 6.2.8. Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох бэлтгэл ажлыг хангах /ТЭЗҮ, Зураг төслийг батлуулсан байна. 10-12 сар. АТБХЗХ/ 30%
 - 6.2.9. Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын олон улсын нөөц нисэх буудал болгох бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, Зураг төслийг батлуулсан байна. 7-9 сар. АТБХЗХ/ 70%
- 4) Дараах ажлууд хөрөнгө, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй байна. Үүнд:
- 3.3.9. Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн болон зөвлөхийн гэрээний хэрэгжилтийг хангуулах 70%
 - 3.4.7.Налайх-Чойр, Улаангом-Хандгайт, Ховд-Улаангом, Мандалговь-Даланзадгад чиглэлийн 177,5 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэх
 - 4.3.1. Тусгай замын автобус /BRT/-г нэвтрүүлэх I шатны ажлыг хэрэгжүүлэх /Тусгай замын автобус /BRT/-г нэвтрүүлэх I шатны барилгын ажлыг эхлүүлсэн байна. 2 улирал АТБХЗГ/ 30%
 - 5.2.1.Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх /барилгын ажлын 80% гүйцэтгэсэн байна. 2-4 улирал. ТЗДТБХЗГ/ 30%
- 5) ХШҮДАГ-ын дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн томилогдоогүй тул дараах арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:
- 7.3.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд ажил, үйлчилгээ эрхэлдэг агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийх /Эрсдэлийн түвшин өндөр үнэлэгдсэн 4 байгууллагад дотоод аудит хийж, тайланг Дотоод аудитын хороонд танилцуулсан байна. 1-4 улирал. ХШҮДАГ/ 0%
- 6) МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 121 арга хэмжээнээс “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 6,6%-ийг эзэлж байна. Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, шүүхийн маргаантай, ТЭЗҮ үр ашиг багатай гарсан, бодлогод тусгаагүй, царигийн хэмжээг тогтоогоогүй, төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигчийг шийдвэрлээгүй зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй “Үнэлэх боломжгүй” 50 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 41,3%-ийг эзэлж байна.
- 7) Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 31 арга хэмжээнээс биелэлт
- 8) Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар



байгуулсан “Санамж бичиг”-т төмөр замын чиглэлээр тусгагдсан 42 арга хэмжээний хэрэгжилт хамгийн бага буюу 58,3%-тай үнэлэгдсэн байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны үйл ажиллагаанд 2019 оны III улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн яамны газар, хэлтсийн дарга нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу ЗГХЭГ-аас баталж ирүүлсэн аргачлал, загварын баримтлан яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний хэрэгжүүлэх хугацааг сар, улирлаар тогтоон улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлын хүрэх түвшинг улирал тус бүрээр тодорхой төлөвлөх, газар, хэлтсүүдийн оролцоог ялгаатай тогтоох;
2. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа арга хэмжээнүүдийн талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлуудыг яаралтай дуусгах;
3. Санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжих боломжтой хууль, эрх зүйн орчинг сайжруулах, бодлогын баримт бичиг боловсруулах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, тайлагнах, байнгын ажиллагаатай ажлыг хэсгүүдийг хуралдуулах зэрэг арга хэмжээнүүдийг хугацаанд нь хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;
4. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан боловч бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ болон ЗГҮАХ, Үндсэн чиглэл, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайд, ТНБД-ын тушаал, СЗХ-аас өгсөн үүрэг даалгаврууд, бусад төлөвлөгөөнд туссан хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган оны эхнээс хяналт тавьж, хариуцсан мэргэжилтнүүдэд үүрэг өгч ажиллах;
5. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2018-2020 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-т тусгагдсан арга хэмжээнүүдийг онцгойлон анхаарч, эрчимжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
6. Холбогдох тайлан, мэдээллийг тодорхой тоо баримт, огноотой, товч тодорхой бичиж, хийсэн ажлаа бүрэн тайлагнаж, журамд заасан хугацаанд ирүүлж байхад яамны нийт ажилтнууд анхаарч ажиллах;

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД



ТЗУГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

БТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.МӨНХНАСАН

АЗБХЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДРАДНАА

ТЗДТБХЗГ-ЫН ДАРГА

Б.АРТУР

АТБХЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНТУЛГА

АТБХЗХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МЯГМАРСҮРЭН

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БАЯРМАА



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

/жилийн эцсийн байдлаар/

№	Хяналтанд байх арга хэмжээ	2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Биелэлт /Хувиар/						Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй	Хүчингүй болсон
				Дундаж хувь	100	70	40	30	0			
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	192	187	88.3	135	37	-	14	1	-	-	5
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	126	76	87.0	51	17	8	-	-	-	50	-
3	Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	31	25	91.6	20	3	2	-	-	-	6	-
4	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт	326	282	88,2	187	83	-	12	-	37	-	7
5	Сайдын тушаалын биелэлт	604	498	83,5	329	101	-	54	14	70	-	36
6	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт	188	174	95,7	153	18	-	3	-	14	-	-
7	ЗГ-ын хуралдаанд оруулах асуудлын төлөвлөгөөний биелэлт	25	19	81.0	12	4	-	2	1	-	-	6
8	Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөний биелэлт	29	29	94.8	24	5	-	-	-	-	-	-
9	Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт	100	97	80.3	44	45	-	8	-	1	2	-
10	Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт	42	40	48.8	3	18	-	13	6	2	-	-
11	Ил тод нээлттэй байдлын үнэлгээ	14	14	95.7	12	2	-	-	-	-	-	-
12	Шилэн данс хөтлөлтийн үнэлгээ	15	15	84.0	7	8	-	-	-	-	-	-
	Нийт дүн	1692	1456	86.0	729	341	10	106	22	124	58	54



Нийт	90.4	97.0	86.6	82.8	86.6	94.0	89.8	86.0
------	------	------	------	------	------	------	------	------

**ЗТХЯ-НЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:
/Хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээгээр/**

/жилийн эцсийн байдлаар/

Дундаж дүн 86,0%



**ЗТХЯ-НЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:
/Яамны бүтцийн нэгжээр/**

/жилийн эцсийн байдлаар/

